



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот


Эрх шилжүүлэн ажил
гүйцэтгүүлэх тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ барилга байгууламжийн жагсаалтаар Эрүүл мэнд, спортын сайдын багцын ХҮ1.1.1.21 Эмнэлгийн барилга, 10 ор /Өвөрхангай, Бүрд сум/-ын ажлын 350,200,000.0 /Гурван зуун тавин сая хоёр зуун мянга/ төгрөгийн гэрээг шинэчлэн байгуулах, сунгах, цуцлах, нэмэлт тендер зарлах эрхийг Өвөрхангай аймгийн Засаг даргад шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т үүрэг болгосугай.

САЙД



Г. ШИЙЛЭГДАМБА